



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 0720

Улаанбаатар хот

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Билгийн тооллын хаврын тэргүүн сар, Сар шинийн баярыг угтан дүүргийн 80-аас дээш настай ахмадуудад хүндэтгэл үзүүлсүгэй.

2.Хүндэтгэл үзүүлэх ахмад настнуудын нэрсийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 3,798,900 (Гурван сая долоон зуун ерэн найман мянга есөн зуу) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т зөвшөөрсүгэй.

4.Хүндэтгэл үзүүлэх ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулан, захирамжийн хэрэгжилтэд хянал тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД